



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/101

Бат-Өлзий сум

Худаг хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын Сум дундын ойн ангид шинээр баригдсан инженерийн хийцтэй худаг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)

Гишүүд: Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Б.Энхмаа (Байгаль хамгаалагч)


Э.Бадамханд (Хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоо хариуцсан мэргэжилтэн)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, гэрээнд заасны шалгуурыг хангасан тохиолдолд хүлээн авч, акт үйлдэн танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Очирхуяг)-д даалгасугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн инженерийн хийцтэй худгийг Засаг даргын Тамгын газрын өмчийн бүртгэлд бүртгэж, ашиглалт хамгаалалтад байнгын хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам), өмч хамгаалах зөвлөл (Э.Дашдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

My Doc Zakhiramj /ZD/ 2023

6223012